

БАТЛАВ

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Л.ОЮУНЖАРГАЛ

“ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ”-Г
2025 ОНД САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 02 дугаар сарын 11

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ		Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах хэлтэс
1.	Гадаад шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр	Албан ёсны цахим хуудас, мэдээллийн самбар дахь үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны мэдээлэл ил тод эсэхэд дүн шинжилгээ хийж, дутуу мэдээллүүдийг байршуулах;	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллүүдийг ил тод байршуулсан байна.	Улирал тутамд	УСУАҮХ
2.		Байгууллагаас хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим орчинд түгээх, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах;	- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр 3-аас доошгүй удаа тухайн байгууллагын талаар мэдээлэл гарсан байх; - 2-оос доошгүй удаа нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан байх;	2-4-р улиралд	УМХ ЗАХ
3.		Олны танил хүмүүсээр байгууллагын үйл ажиллагааг сурталчлуулсан бичлэг, сэтгэгдэл, пост мэдээлэл цахим орчинд оруулах, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах;	- Олны танил 3-аас доошгүй хүмүүсээр байгууллагын сурталчилгааг хийлгэсэн байх;	2-4-р улиралд	УМХ
4.		Байгууллагын албан хаагчдад иргэдтэй хүндэтгэлтэй харилцах, ажлын цагийг баримтлах, ёс зүйн зөрчил гаргахгүй байх, иргэний гаргасан хүсэлтэд дурдсан асуудлыг бүрэн дүүрэн тайлбарлаж өгч байх, төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автахгүй байх, бусдад хууль бус давуу байдал олгохгүй байх, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахыг хориглох, эсхүл бусдад дамжуулахгүй байх, бусдаас	- Бүх албан хаагчдаар баталгаа гаргуулсан байх; - Албан хаагчдад сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байх;	2-4-р улиралд	ЗАХ

		шан харамж авахгүй байх, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэхгүй байх, хувийн ашиг сонирхол гаргахгүй байх талаар баталгаа гаргуулах, эдгээр зөрчлийг гаргахгүй байхад чиглэсэн соён гэгээрүүлэх, сургалт зохион байгуулах;			
5.		Тухайн байгууллагаас иргэд, олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний хугацаа, чанар, хүртээмжид дүн шинжилгээ хийж, хүнд суртал, чирэгдэл үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, арилгахад чиглэсэн арга хэмжээ авах;	-Дүн шинжилгээ, ажлын байрны зураглал хийсэн байх; - Үр дүнгээс хамааран хүнд суртал, чирэгдлийг бууруулах арга хэмжээ авсан байх;	2-4-р улиралд	УМХ
6.		Тухайн байгууллагын албан хаагчид албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах нь авлигын гэмт хэрэг болон зөрчлийн шинжтэй үйлдэл болох талаар нийт албан хаагчдад сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах;	-Сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байх;	1, 3-р улиралд	ЗАХ
7.	Дотоод шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр	Авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрдүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг удирдлагын зүгээс хамгаалах, дарамт шахалт үзүүлэхгүй гэдгээ нийт албан хаагчдад илэрхийлэх;	- Авлигын зөрчлийн талаар мэдээлэл өгөх сувгуудыг сурталчилсан байх; - Мэдээ, мэдээллийн мөрөөр хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, буруутай албан хаагчдад хариуцлага тооцсон байх;	Жилдээ	ЗАХ
8.		Байгууллагын дотоод шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор бүх албан хаагчдыг нууц санал асуулгад хамруулах арга хэмжээ авах, санал асуулгын үр дүнд үндэслэн Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэл, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авах;	-Албан хаагчдыг санал асуулгад бүрэн хамруулсан байх; - АТГ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлсэн байх;	Жилдээ	ЗАХ
9.	Бодлогод оролцогчдын үнэлгээг сайжруулах чиглэлээр	Байгууллагын удирдах албан тушаалтан нийт хаагчдад шударга байдлын үнэлгээг сайжруулахад чиглэсэн албан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, албан хаагчдаас гарсан авлигын эсрэг санал санаачилгыг дэмжин ажиллах	-Нийт албан хаагчдад шударга байдлын үнэлгээг сайжруулахад чиглэсэн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулагдсан байх;	Жилдээ	ЗАХ